

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,  
ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ  
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРЛЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2012 оны 06 дугаар  
сарын 29 ны өдөр

Дугаар 385, А/248

Улаанбаатар  
хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Цагдаа, шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчид хэргийн газрын үзлэгт хамтран ажиллах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Тушаал, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Мөрдөн байцаах газар, Замын цагдаагийн газар, Нийслэлийн цагдаагийн газар, дүүргийн цагдаагийн хэлтэс, шүүхийн шинжилгээний байгууллагын хэлтэс, албаны дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаал, журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлт үр дүнг хагас, бүтэн жилээр танилцуулж байхыг Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газар /цагдаагийн хурандаа Ц.Арвинбуудай/, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Тамгын хэлтэс /цагдаагийн хурандаа Ж.Мөнхбаатар/-т тус тус даалгасугай.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА, ХОШУУЧ ГЕНЕРАЛ  
Д. САНДАГ-ОЧИР



ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ  
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА  
Ч. АЛТАНХИШИГ



Цагдаагийн ерөнхий газрын дарга, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын хамтарсан 2012 оны 38-р тушаалын хавсралт

## ЦАГДАА, ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧИД ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГТ ХАМТРАН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Цагдаа, шүүхийн шинжилгээний байгууллагаас хүний амь нас хохирсон хэргийн газрын үзлэгийг хамтран хийх, цогцос зөөвөрлөх, түүнд шинжилгээ хийх ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэхтэй холбогдсон ажлын уялдааг сайжруулах, Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны тасралтгүй шуурхай байдлыг хангахад энэхүү журмын зорилго оршино.

1.2 Цагдаа, шүүхийн шинжилгээний байгууллага нь хүний амь нас хохирсон хэргийн газрын үзлэгийг хамтран хийх, цогцос зөөвөрлөх, түүнд шинжилгээ хийхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Цагдаагийн байгууллагын тухай хууль, Шүүхийн шинжилгээний тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.3 Энэ журмыг нийслэлийн цагдаагийн газар, мөрдөн байцаах газар, замын цагдаагийн газар, дүүргийн цагдаагийн хэлтэс, төмөр замын цагдаагийн хэлтэс, шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн криминалистикийн болон шүүх эмнэлгийн шинжилгээний хэлтэс, нийслэлийн шүүхийн шинжилгээний албаны бүх алба хаагчид дагаж мөрдөх бөгөөд нийт бие бүрэлдэхүүнд таниулах, мөрдөж хэвшүүлэх ажлыг Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Тамгын хэлтэс зохион байгуулна.

1.4 Талууд мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, хойшлуулшгүй шуурхай арга хэмжээний үед цагдаагийн байгууллагын дотоод нэгдсэн сүлжээг ашиглан шаардлагатай мэдээллийг цахим хэлбэрээр солилцоно.

Хоёр. Байгууллагуудын нийтлэг эрх, үүрэг

2.1 Хамтын ажиллагааны явцад хоёр байгууллагын зүгээс тавьсан асуудлыг тухай бүр удирдлагын хэмжээнд хэлэлцэж шийдвэрлэнэ.

Гурав. Цагдаагийн байгууллага, алба хаагчийн эрх, үүрэг

3.1 Мэдээлэл, шуурхай удирдлагын төв, дүүргийн цагдаагийн хэлтсийн жижүүр нь хүний амь нас хохирсон хэргийн дуудлагыг хүлээн авсан тохиолдолд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, нийслэлийн шүүхийн шинжилгээний албанд мэдэгдэж, хэргийн газрын үзлэгт оролцуулах криминалистикийн мэргэжилтэн, шинжээч эмч болон цогцос зөөвөрлөх тусгай зориулалтын тээврийн хэрэгслийг дуудаж, хамтран ажиллана.

Хэргийн нөхцөл байдлыг харгалзан шаардлагатай бол галт зэвсэг, хими, биологи, физикийн нарийн мэргэжлийн шинжээчдийн баг оролцуулах хүсэлт тавина.



3.2 Хэргийн газрын үзлэгийн бүрэлдэхүүн нь Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2010 оны 189/385 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Цогцост шинжилгээ хийх журам”-ын 1.3 дахь хэсэгт заасныг баримтална.

3.3 Шүүх эмнэлгийн байранд цогцосны үзлэг, задлан шинжилгээг явуулах тохиолдолд шинжилгээ хийлгэх тогтоол үйлдсэн мөрдөн байцаагч, шаардлагатай бол эрүүгийн төлөөлөгчийг байлцуулна.

3.4. Мөрдөн байцаагч нь хойшлуулшгүй тохиолдолд тухайн цогцост нэн даруй нарийвчилсан үзлэг, задлан шинжилгээг хийх хүсэлтийг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн шүүх эмнэлгийн хэлтэст тавьж, урьдчилан дүгнэлтийг гаргуулна.

Дөрөв. Шүүхийн шинжилгээний байгууллага, ажилтны эрх, үүрэг

4.1 Энэ журмын 3.1 дэхь хэсэгт заасны дагуу ирүүлсэн мэдээллийг хүлээн авч, нэн даруй хэргийн газрын үзлэгт оролцуулах криминалистикийн мэргэжилтэн, шинжээч эмч, цогцос зөөвөрлөх тусгай зориулалтын тээврийн хэрэгслийг ажиллуулна. Хэргийн нөхцөл байдлыг харгалзан шаардлагатай бол галт зэвсэг, хими, биологи, физикийн нарийн мэргэжлийн шинжээчдийн баг оролцуулна.

4.2 Шуурхай албаны жолооч нь хэргийн газарт яаралтай очиж цагдаагийн болон үзлэг хийсэн бүрэлдэхүүний хамт цогцосыг зөөвөрлөж шүүх эмнэлгийн жижүүрийн үүрэг гүйцэтгэж байгаа шинжээч эмч, туслах ажилтанд хүлээлгэн өгнө.

4.3 Жолооч нар нь үйлдэгдсэн хэргийн холбогдолтой нөхцөл байдал, төрийн байгууллага, хувь хүний нууцтай холбоотой асуудлыг бусдад задруулах, мэдээлэл хийхгүй байх үүрэг хүлээнэ.

4.4 Жолооч нар эзэмшиж буй автомашины албаны шуурхай бэлэн байдлыг хангаж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны болон замын хөдөлгөөний дүрмийг чанд сахиж ажиллана.

4.5 Хэргийн газарт ажиллаж буй шинжилгээний байгууллагын алба хаагч нь шинжилгээний объект, цогцосыг зориулалтын зөөвөрлөх уут, нэг удаагийн бээлий, савлах уут, баглаа, бүтээлгэ, дамнуурга зэргийг ашиглана.

4.6 Энэ журмын 3.5 дахь хэсэгт заасны дагуу мөрдөн байцаагчаас тавьсан хүсэлтийн дагуу тухайн цогцост нэн даруй нарийвчилсан үзлэг, задлан шинжилгээг хийж, гадны нөлөөтэй эсэх, нас барсан цаг хугацаа, бусад хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар урьдчилсан мэдээллээр хангана.

Тав. Бусад зүйл

5.1 Монгол Улсын Ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 153/158 тоот хамтарсан тушаалын дагуу “Эдгэшгүй хүнд өвчний улмаас удаан хугацаагаар бусдын асаргаанд байхдаа гэртээ нас барсан нь өвчний түүх, эмчийн тодорхойлолтоор тогтоогдсон тохиолдолд нас барсан иргэдийн цогцосыг яаралтай түргэн тусламжийн дуудлагын машинаар шүүх эмнэлгийн болон бусад эмнэлгийн цогцос хадгалах байранд хүргүүлж болно.

5.2 Энэ журмыг зөрчсөн буруутай алба хаагчид холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗАР

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН